



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Есөнбулаг сумын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ГАА-2022/83/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор Р.Цанжидмаа Утас: 99029885 Цахим хаяг: tsania.0215@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	9
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	13
4. Аудитын илрүүлэлт .....	14
4.4 Зөвлөмж .....	15
1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



Г ЕСӨНБУЛАГ СУМЫН 2 ДУГААР  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Э.ТЭРБИШ  
ТАНАА

## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 90

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Есөнбулаг сумын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Есөнбулаг сумын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

07020375

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х ТҮВШИНБАЯР



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>82,279,086.66</u></b>	<b><u>93,737,956.97</u></b>
<b>АВЛАГА</b>	1,475,343.00	0.00
Ажиллагчидтай холбогдсон авлага	1,016,014.00	0.00
<b>Бусад авлага</b>	459,329.00	-
Хувь хүмүүсээс авах авлага	459,329.00	
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	80,803,743.66	93,737,956.97
<b>Түүхий эд материал</b>	50,837,280.35	56,575,356.40
Тусгай зориулалттай материал	50,837,280.35	55,812,856.40
Эм боох материал		762,500.00
<b>Хангамжийн материал</b>	29,966,463.31	37,162,600.57
Бичиг хэргийн материал	696,000.00	696,000.00
Аж ахуйн материал	2,538,148.00	5,956,600.00
Бусад хангамжийн материал	26,732,315.31	30,510,000.57
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,823,933,626.91</u></b>	<b><u>1,808,352,426.46</u></b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,823,933,626.91	1,808,352,426.46
<b>Биет хөрөнгө</b>	1,674,873,626.91	1,631,417,426.46
Барилга, байгууламж, орон сууц	1,496,007,211.36	1,496,007,211.36
Хуримтлагдсан элэгдэл	- 90,642,140.58	- 136,792,097.82
Машин тоног төхөөрөмж (компьютер)	206,355,433.67	219,028,342.11
Хуримтлагдсан элэгдэл	- 106,650,750.40	- 116,499,751.52
Тавилга, аж ахуйн эд хогшил	249,638,692.28	267,775,621.27
Хуримтлагдсан элэгдэл	- 116,587,252.13	- 134,854,331.65
Бусад үндсэн хөрөнгө	36,752,432.71	36,752,432.71
<b>Биет бус хөрөнгө</b>	149,060,000.00	176,935,000.00
Програм хангамж	2,843,610.00	2,038,750.00
Хуримтлагдсан элэгдэл	- 1,783,610.00	- 1,083,750.00
Бусад биет бус хөрөнгө	148,000,000.00	175,980,000.00
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,906,212,713.57</u></b>	<b><u>1,902,090,383.43</u></b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b><u>58,278.00</u></b>
<b>Өглөг</b>	-	58,278.00
<b>Бусад өглөг</b>	-	58,278.00
Байгууллагад төлөх өглөг		58,278.00
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,906,212,713.57</u></b>	<b><u>1,902,032,105.43</u></b>
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,906,212,713.57	<u>1,902,032,105.43</u>
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийнсан	1,193,983,896.63	1,221,963,896.63
Өмч: - төрийн	1,193,983,896.63	1,221,963,896.63
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	- 85,431,431.94	- 117,592,040.08
Өмнөх үеийн үр дүн	- 145,835,292.69	- 85,431,431.94
Тайлант үеийн үр дүн	60,403,860.75	- 32,160,608.14
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	797,660,248.88	797,660,248.88
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,906,212,713.57</u></b>	<b><u>1,902,090,383.43</u></b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,605,200,684.93</b>	<b>1,546,123,473.96</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>142,583,128.93</b>	<b>37,348,726.96</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	142,583,128.93	37,348,726.96
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	101,732,839.93	12,836,000.31
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	101,732,839.93	12,836,000.31
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	40,850,289.00	24,512,726.65
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,462,617,556.00</b>	<b>1,508,774,747.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,202,426,700.00	1,274,796,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,202,426,700.00	1,274,796,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	32,390,856.00	10,181,747.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,734,356.00	8,419,147.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,656,500.00	1,762,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	227,800,000.00	223,797,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	227,800,000.00	223,797,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,540,966,760.18</b>	<b>1,578,259,982.10</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,540,966,760.18</b>	<b>1,578,259,982.10</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,438,604,048.92	1,510,611,124.59
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,003,628,492.74	1,026,177,072.37
210101	Үндсэн цалин	915,091,855.74	936,236,507.31
210104	Урамшуулал	88,536,637.00	89,940,565.06
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	124,371,810.00	133,606,404.12
210201	Тэтгэврийн даатгал	95,828,401.00	93,192,736.83
210202	Тэтгэмжийн даатгал	-	10,345,231.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,070,044.00	8,286,268.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,861,214.00	1,980,198.75
210205	Эрүүл мэндийн даатгал	18,612,151.00	19,801,969.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	190,774,885.00	216,392,774.00
210301	Гэрэл, цахилгаан	3,924,401.00	5,583,278.00
210302	Түлш, халаалт	180,475,178.00	207,244,000.00
210303	Цэвэр, бохир ус	6,375,306.00	3,565,496.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,339,907.00	7,434,113.00
210401	Бичиг хэрэг	2,882,250.00	799,975.00
210402	Тээвэр, шатахуун	600,000.00	497,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,169,257.00	2,999,138.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,134,400.00	233,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,554,000.00	2,905,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	624,800.00	1,112,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	474,800.00	1,112,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	150,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,244,700.00	7,453,000.00
210604	Урсгал засвар	10,244,700.00	7,453,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	385,600.00	298,000.00
210702	Дотоод албан томилолт	385,600.00	298,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,452,500.00	4,341,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,656,500.00	4,066,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	275,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	95,781,454.18	113,796,261.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	603,500.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,689,500.00	10,562,334.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	91,488,454.18	103,233,927.10
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>102,362,611.26</b>	<b>67,648,857.51</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>55,788,356.00</b>	<b>48,773,500.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,954,000.00	41,173,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29,734,356.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,100,000.00	7,600,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	24,025,115.00	9,504.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,025,115.00	9,504.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	22,549,140.26	18,865,853.51
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,549,140.26	18,865,853.51
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>64,233,924.75</b>	<b>(32,136,508.14)</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,830,064.00</b>	<b>24,100.00</b>
225002	Найдваргүй авлагын алдагдал	3,830,064.00	24,100.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>60,403,860.75</b>	<b>(32,160,608.14)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
С08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,193,983,896.63	797,660,248.88	-85,431,431.94	1,906,212,713.57
Д01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,193,983,896.63	797,660,248.88	-85,431,431.94	1,906,212,713.57

D0 2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D0 3	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,193,983,896.63</b>	<b>797,660,248.88</b>	<b>-85,431,431.94</b>	<b>1,906,212,713.57</b>
D0 5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	27,980,000.00	0.00	0.00	27,980,000.00
D0 8	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-32,160,608.14	-32,160,608.14
D0 9	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,221,963,896.63</b>	<b>797,660,248.88</b>	<b>-117,592,040.08</b>	<b>1,902,032,105.43</b>

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,473,517,556.00</u></b>	<b><u>1,508,774,747.00</u></b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,473,517,556.00</b>	<b>1,508,774,747.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,202,426,700.00	1,274,796,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,202,426,700.00	1,274,796,000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	43,290,856.00	10,181,747.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,634,356.00	8,419,147.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,656,500.00	1,762,600.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	227,800,000.00	223,797,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	227,800,000.00	223,797,000.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,455,608,256.00</u></b>	<b><u>1,473,614,747.00</u></b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,455,608,256.00</b>	<b>1,473,614,747.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,353,245,644.74</b>	<b>1,405,965,889.49</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,004,278,223.74	1,024,913,159.49
210101	Үндсэн цалин	915,741,588.45	934,972,594.43
210104	Урамшуулал	88,536,635.29	89,940,565.06
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	124,294,286.00	133,419,074.00
210201	Тэтгэврийн даатгал	95,670,470.00	93,192,732.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	10,345,233.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,073,406.00	8,098,942.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,868,219.00	1,980,197.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,682,191.00	19,801,970.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	190,774,885.00	216,334,496.00

210301	Гэрэл, цахилгаан	3,924,401.00	5,525,000.00
210302	Түлш, халаалт	180,475,178.00	207,244,000.00
210303	Цэвэр, бохир ус	6,375,306.00	3,565,496.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8,133,607.00</b>	<b>8,129,113.00</b>
210401	Бичиг хэрэг	1,209,950.00	799,975.00
210402	Тээвэр, шатахуун	600,000.00	497,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,169,257.00	2,999,138.00
210404	Ном, хэвлэл	520,000.00	500,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,134,400.00	233,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,500,000.00	3,100,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>699,800.00</b>	<b>2,025,000.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	549,800.00	1,875,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	150,000.00	150,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,407,243.00</b>	<b>7,453,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,941,543.00	
210602	Тавилга	-	
210604	Урсгал засвар	13,000,000.00	7,453,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>385,600.00</b>	<b>298,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	385,600.00	298,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,452,500.00</b>	<b>4,341,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,656,500.00	4,066,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	275,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>8,819,500.00</b>	<b>9,053,047.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	603,500.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,216,000.00	9,053,047.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>102,362,611.26</b>	<b>67,648,857.51</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>55,788,356.00</b>	<b>48,773,500.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,954,000.00	41,173,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29,734,356.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,100,000.00	7,600,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>24,025,115.00</b>	<b>9,504.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,025,115.00	9,504.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>22,549,140.26</b>	<b>18,865,853.51</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,549,140.26	18,865,853.51
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>17,909,300.00</u></b>	<b><u>35,160,000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b><u>17,909,300.00</u></b>	<b><u>35,160,000.00</u></b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b><u>17,909,300.00</u></b>	<b><u>35,160,000.00</u></b>
2200	Дотоод эх үүсвэрээр	17,909,300.00	35,160,000.00

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,909,300.00	35,160,000.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-17,909,300.00</b>	<b>-35,160,000.00</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,498,593,000.00	1,479,717,642.49
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,498,593,000.00	1,479,717,642.49
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,449,002,500.00	1,431,744,142.49
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,037,443,000.00	1,024,913,159.49
210101	Үндсэн цалин	943,441,000.00	934,972,594.43
210104	Урамшуулал	94,002,000.00	89,940,565.06
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	138,133,600.00	133,419,074.00
210201	Тэтгэврийн даатгал	96,716,800.00	93,192,732.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,482,800.00	10,345,233.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,386,000.00	8,098,942.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,049,000.00	1,980,197.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,499,000.00	19,801,970.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	216,344,000.00	216,334,496.00
210301	Гэрэл, цахилгаан	5,525,000.00	5,525,000.00
210302	Түлш, халаалт	207,244,000.00	207,244,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,575,000.00	3,565,496.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,130,000.00	8,129,113.00
210401	Бичиг хэрэг	800,000.00	799,975.00
210402	Тээвэр, шатахуун	497,000.00	497,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000,000.00	2,999,138.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	500,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	233,000.00	233,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,100,000.00	3,100,000.00
2105	<b>Нормативт зардал</b>	2,025,000.00	2,025,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,875,000.00	1,875,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	150,000.00	150,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	41,453,000.00	41,453,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,000,000.00	17,000,000.00
210602	Тавилга	17,000,000.00	17,000,000.00
210604	Урсгал засвар	7,453,000.00	7,453,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	300,000.00	298,000.00

210702	Дотоод албан томилолт	300,000.00	298,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>852,000.00</b>	<b>850,400.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	576,000.00	575,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	276,000.00	275,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,321,900.00</b>	<b>4,321,900.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,321,900.00	4,321,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>49,590,500.00</b>	<b>47,973,500.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>49,590,500.00</b>	<b>47,973,500.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,790,500.00	41,173,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,800,000.00	6,800,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,498,593,000.00</b>	<b>1,479,717,642.49</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,274,796,000.00</b>	<b>1,255,930,146.49</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,274,796,000.00	1,255,930,146.49
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>223,797,000.00</b>	<b>223,787,496.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	223,797,000.00	223,787,496.00

### 2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Эд/згийн ангилал	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>10,181,747.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>10,181,747.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>9,381,747.00</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,160,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,160,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,490,600.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,490,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,731,147.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,731,147.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>800,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>800,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>10,181,747.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>10,181,747.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,419,147.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,762,600.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-ний Говь-Алтай салбарын захирал, аудитор Р.Цанжидмаа гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 07 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Боловсролын тухай хуульд заасны дагуу Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: “Суралцагч бүрийн сурлагын чанарыг ахиулна”

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахаар даалгасан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлого 1,430.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 28.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 22.8 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын дүн болох 1,546.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 30.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 24.7 сая төгрөгөөр тогтоогдож байна.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 2 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8.2 хувиар буюу 4.6 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь үндсэн хөрөнгө акталж данснаас хассантай холбоотой байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 93,7 сая төгрөг болж 12,9 сая төгрөгөөр өссөн нь хангамжийн материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 61,7 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 12,8 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 61,5 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 93,7 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,197.6 сая төгрөг болж 57.9 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 35.1 сая төгрөг, хандив тусламжаар үнэ төлбөргүйгээр 24,5 сая төгрөгийн хөрөнгө, 27.8 сая төгрөгийн бусад биет бус хөрөнгө буюу газар орлого авсан 29.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталж данснаас хассантай холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,902.0 сая төгрөг болж 4.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 2.4

хувиар буюу 35.3 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлоготой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 1,902.0 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,368.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 129.7 сая төгрөгөөр өсгөж, 1,498.5 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс өндөр байгаа нь хүүхдийн хоолны зардал 1500 төгрөг болж өссөнтэй холбоотой байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн 5 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 1,498.6 сая төгрөгийн төсөв баталснаас 1,274.7 сая төгрөгийг улсын төсвөөс 223.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,274.7 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 223.9 сая төгрөг нийт 1,498.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,479.7 сая төгрөгийг зарцуулж 18.9 сая төгрөгийг улсын төсөвт, 0.009 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,479.7 сая төгрөг буюу 98 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 12.6 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 4.7 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.009 сая төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардлыг 1.6 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 0.002 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар Дээд шатны төсвийн захирагчаас 8.4 сая төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 1.7 сая төгрөг нийт 10.1 сая төгрөгийн санхүүжилтийг авчээ.

Үүнээс багаж техник хэрэгслийн зардалд 1.1 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардалд 0.8 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 3.5 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 4.7 сая төгрөгийг зарцуулж үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 2021 оны 1,498.5 сая төгрөгийн 114 мэдээллийг ил тод байршуулахаас 1,498.5 сая төгрөгийн 114 мэдээллийг ил тод байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 11.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.Аудитаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан тухай албан бичиг ирүүлсэн.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн жилийн аудитаар:

- Бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах
- Төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 19.3 сая төгрөгийн зөрчил, илэрч албан шаардлага хүргүүлээ.

##### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулга хийгдээгүй

##### 4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

##### 4.3 Албан шаардлага

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлаагүйгээр төсвийн хөрөнгөөр 8.5 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай"-ын 1.4-д заасан "Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад авто машин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлан, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Хөндлөнгийн мэдээлэлтэй тулган баталгаажуулахад 6.6 сая төгрөгийн түлш халаалтын өглөгтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасныг зөрчсөн, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Цалингийн батлагдсан төсөвт хоолны зардал төлөвлөгдөөгүй байхад 12 сард хоолны хөнгөлөлт 10.9 сая төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах", Говь-Алтай аймгийн Боловсрол соёл урлагийн газрын 2021 оны 01 сарын 27-ны өдрийн 29 тоот албан бичиг"-тэй нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### 4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй

#### 1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Есөнбулаг сумын 2 дугаар сургууль	3	19.3	-	-	0.0	0.0	3	19.3		